



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 660

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин Сайдын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 49,815.48 (дөчин есөн мянга найман зуун арван таван ам.доллар дөчин найман цент) ам.долларын балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотод суугаа Консулын газарт балансад шилжүүлсүгэй.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр болон хавсралтад заасан Элчин Сайд, Ерөнхий консул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож санхүүгийн тайланд тусгах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн Өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020  
оны 12 дугаар сарын 08-ний өдрийн 660 дугаар  
тогтоолын хавсралт

**БНХАУ-ЫН БЭЭЖИН дахь Элчин Сайдын яамны балансаас Манжуур дахь Ерөнхий  
консултын газарт балансад шилжүүлэн бүртгэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (ам.доллараар)	Балансын үнэ (ам.доллараар)	Хуrimтлагдсан элэгдэл (ам.доллараар)	Цаашид ашиглах хугацаа	Шинэ тогтоосон үнэ (ам.доллараар)
1	Мерседес Бенз 200 маркийн, арлын дугаар WDD2120341B1351778 суудлын автомашина	2015	Ш	1	49,815.48	49,815.48	49,815.48	5	25,956.50
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			1 (нэг)		49,815.48 (дөчин есөн мянга найман зуун арван таван ам.доллар дөчин найман цент)	49,815.48 (дөчин есөн мянга найман зуун арван таван ам.доллар дөчин найман цент)		25,956.50 (хорин таван мянга есөн зуун тавин зургаан ам.доллар тавин цент)